

БИЗНЕС САНААНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХ АГУУЛГА

Дараах асуултуудын хариултууд бодит баримт, мэдээлэлд үндэслэсэн байх шаардлагатайг анхаарна уу. Мөн мэдээллийн эх сурвалжаа дурьдсан байх ёстойг анхаарна уу.

БИЗНЕС САНААГААР ШИЙДЭХИЙГ ЗОРЬЖ БУЙ АСУУДАЛ

- Тухайн бизнес санаагаар ямар асуудлыг шийдэхээр зорьсон вэ?
- Асуудал шийдэгдсэнээр хэний, ямар хэрэгцээг хангах вэ?
- Тухайн шийдвэрлэхийг зорьж буй асуудал нь зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудал мөн үү?
- Одоогийн нөхцөлд бизнес санааны шийдлээр хангагдах хэрэгцээгээ хэрэглэгчид хэрхэн хангаж байна вэ?
- Зах зээлийн хэмжээ?
- Зах зээлийн өсөлт?

ШИЙДЭЛ

- Бизнес санаагаар санал болгож буй шийдэл юу вэ?
- Бизнес санааны шийдлийн харьцангуй давуу тал юу вэ? Бусад шийдлүүдтэй харьцуулахад.
- Шийдлийн хөгжүүлэлт төлөвлөлтийнхөө ямар түвшинд байгаа вэ?
- Шийдлийг зах зээлд нэвтрүүлэхэд хэдий хэр хугацаа шаардах вэ?

БИЗНЕСИЙН ЗАГВАР

- Бизнесийн загвар юу вэ? Хэрхэн ажиллах вэ?
- Бизнес санааг хэрэгжүүлэхэд ямар оролцогч талууд зайлшгүй шаардлагатай вэ?

БАГ

- Бизнес санаагаа хэрэгжүүлэх мэргэжлийн мэдлэг, чадвар байгаа юу?
- Өмнө нь ямар нэгэн төсөл хэрэгжүүлсэн туршлагатай байна уу?
- Бизнес санаагаа хэрэгжүүлэхийн тулд **яагаад одоогийн баг** бүрдсэн вэ?
- Яагаад танай баг энэ бизнесийг хийхээр зорьсон вэ?

БИЗНЕС САНААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОНОВЧТОЙ ЦАГ МӨЧ

- Бизнес санааг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь нөхцлүүд /техник технологийн хөгжил, хэрэглэгчдийн хэрэглээний зан төлөв гэх мэт/ сүүлийн жилүүдэд хэрхэн өөрчлөгдсөн вэ?
- Эдгээр өөрчлөлтүүд нь бизнес санааг хэрэгжүүлэх боломжийг олгосон уу? Яагаад?

ӨРГӨЖИХ БОЛОМЖ

- Бизнес санаагаар бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг өргөтгөх боломжтой юу?
- Бизнес санаагаар бий болох бүтээгдэхүүн үйлчилгээг өөр зах зээлд /өөр улс оронд/ гаргах боломжтой юу?

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Хөрөнгө оруулалтын зарцуулалт?
- Хэдий хэмжээний хөрөнгө оруулалтаар хугарлын цэгтээ /компанийн орлого үйл ажиллагааны зардлаа нөхөх/ хүрэх вэ?
- Хугарлын цэгтээ /компанийн орлого үйл ажиллагааны зардлаа нөхөх/ хүрэхэд хэдий хугацаа шаардах вэ?

ӨРСӨЛДӨӨН

- Бизнес санаатай ижилхэн бизнесийг хэн нэгэн эрхлэж байна уу?
- Өөр хэн нэгэн бизнес санааг хэрэгжүүлэх боломжтой юу?

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

- Тусгайлсан ямар нэг хуулийн хүрээнд эсвэл тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулах уу?

БИЗНЕС САНААГАА ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БАЙГАА СААД, БЭРХШЭЭЛ, АСУУДАЛ

- Бизнес санаагаа хэрэгжүүлэхэд учирч буй саад юу байна вэ?
- Бизнес санаагаа хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл юу байна вэ?
- Бизнес санаагаа хэрэгжүүлэхэд учирч буй асуудал юу байна вэ?